

“ЭХ , ЭМЭГТЭЙЧҮҮД, УРАГ, НЯРАЙ, ХҮҮХДИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУЛГАМДСАН АСУУДЛУУД” ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ III ХУРЛЫН ТАЙЛАН

2025.03.27

Улаанбаатар хот

Дэлхийн эмч нарын өдрийг угтан Эх, нярай эмэгтэйчүүдийн үндэсний төв нь жил бүр уламжлал болгон зохион байгуулагддаг Эрдэм шинжилгээ судалгааны III хурал 2025 оны 03-р сарын 26-ний өдөр амжилттай зохион байгуулагдсан. Тус хуралд 20 эмч, эмнэлгийн мэргэжилтэн судлаач нарын 23 судалгааны ажлыг хүлээн авч хэлэлцүүлэгдэв.

Эрдэм шинжилгээний бага хурлын шүүгчээр:

- У.Цэвэгмид Анагаах ухааны доктор, Дэд профессор, Эрдэмтэн нарийн бичгийн дарга
- Г.Энхтөр, Анагаах ухааны доктор, Клиникийн профессор, Эрдмийн зөвлөлийн гишүүн
- М.Ундрам- Анагаах ухааны доктор, Эрдмийн зөвлөлийн гишүүн
- Д.Мөнхцэцэг – Анагаах ухааны доктор, Эрдмийн зөвлөлийн гишүүн
- Ц.Үржиндэлгэр –Анагаах ухааны доктор, Эрдмийн зөвлөлийн гишүүд нар илтгэлүүдийг шүүн хэлэлцсэн.



Эрдэм шинжилгээ, судалгааны III хуралд оролцсон эмч судлаач нарыг илтгэлийг шүүж эхний 3 байр эзлүүлэн өргөмжлөл мөнгөн шагналаар шагнаж урамшууллаа. Үүнд.

🏆 Тэргүүн байранд:

Б.Алтанбаяр, Дүрс оношилгооны эмч “Хөхний оношилгоог маммографийн хиймэл оюун ухааны /AI/ тусламжтай харьцуулан судалсан нь”

🏆 Дэд байранд:

Э.Намуун, Хүүхдийн эмнэлгийн, Хүүхдийн эмч “Хүүхдийн яаралтай тусламжийн тасагт ажиглалт хийсэн үр дүн”

🏆 Гутгаар байранд:

Р.Наранхүү, Эх барих эмэгтэйчүүдийн эмнэлгийн, Эх, барих эмэгтэйчүүдийн эмч “Умайн хүзүүний дутмагшилтай эхчүүдийг дагаж судалсан судалгааны дүн” сэдвээр тус тус байр эзэллээ.



Дүгнэлт: Эрдэм шинжилгээ, судалгааны ажлын III хуралд оролцсон эмч судлаач нарын илтгэлүүдийг бүтээл болгон хэвлүүлж гарын авлагаар ханган ажилласан.

Илтгэлийг хэлэлцүүлсэн эрдэмтэн доктор, профессор нар илтгэл тавьсан судлаач эмч нарт судалгааны ажлыг хэрхэн бичих, цаашид анхаарах, арга зүйн талаар зөвлөгөөг өгөн ажилласан.

Судалгаа, шинжилгээ, хурал зөвлөгөөн зохион байгуулах Олон улсын жишигт хүрэхүйц 60 хүний суудалтай сүүлийн үеийн тоног төхөөрөмжөөр бүрэн тоноглогдсон “Эрдмийн өргөө” -ний нээлт хийж энэ удаагийн эрдэм шинжилгээний хурлыг шинэхэн танхимдаа зохион байгуулснаараа онцлог боллоо.

